



ТЭЭВЭР ДАРХАН

“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 21 өдөр

№ 01.

Дархан уул аймаг

**Компанийн 2022 оны санхүүгийн
тайлан, Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн хараат бус гишүүдийн
гаргасан дүгнэлтийг хэлэлцэж
батлах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11, 62 дугаар зүйлийн 62.1.9, “Тээвэр Дархан” Хувьцаат компанийн дүрмийн 7.8 дугаар зүйлийн 7.8.3 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Тээвэр Дархан” ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн тайланг баталсугай.
2. Тус компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг шинээр байгуулагдах Төлөөлөн удирдах зөвлөлд, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал М.Оюунд тус тус үүрэг болгосугай.

Хурлын дарга



Ж.ОЧИРСҮХ



ТЭЭВЭР ДАРХАН

“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 21 өдөр

№ 02

Дархан уул аймаг

Ногдол ашиг олгох тухай.

“Тээвэр дархан” ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 2 сарын 18-ны өдрийн тогтоол, хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4-р сарын 21-ны өдрийн хурлын тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Ээлжит хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 300 төгрөгөөр олгосугай.
2. Ногдол ашгийг 2023 оны 12-р сарын 31-ний дотор олгохыг гүйцэтгэх захирал М.Оюунд үүрэг болгосугай.



/ Ж.Очирсүх /